

БАТЛАВ.
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД СУДЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ - АХЛАХ ЗЭРЭГ

Мэргэшлийн зэрэг горилогчид тавигдах нийтлэг шаардлага

1. Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр мэргэжлийн диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэхтэй байх;
2. Тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр тасралтгүй ажилласан байх,
3. Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх;
4. Жил тутам биелүүлсэн багц цагийн сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж буй мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр байх;
5. Ажилладаг байгууллага, хамт олны хөгжилд хувь нэмэр оруулах үйл ажиллагааг жил тутам зохион байгуулсан байх (тайланг хавсаргах);
6. Тухайн мэргэжил, үндсэн мэргэшлээр ажилласан сүүлийн 5 жилд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх; Мэргэшлийн ахлах зэрэг горилогчид (ЭМУЗБ) тавигдах тусгай шаардлага;

Ахлах зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуур

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг, санаачлагатай гүйцэтгэж ирсэн, хамт олны хүндэтгэлийг хүлээсэн (хамт олны хурлын тэмдэглэл);
2. Сүүлийн 3 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 3-с доошгүй илтгэл 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх);
3. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 3-оос доошгүй өгүүллийг 1-р зохиогчоор болон хамтран зохиогчоор хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх);
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод, гадаадад мэргэжлийн сургалтанд хамрагдсан, сүүлийн 5 жил тус бүр 2 багц цагийн сургалтанд хамрагдсан байх (гэрчилгээ болон сургалтанд хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил бүрээр хавсаргах);

ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ – ТЭРГҮҮЛЭХ ЗЭРЭГ (ШИНЭЧЛЭН ТОГТООХ)

Мэргэшлийн зэрэг горилогчид тавигдах нийтлэг шаардлага

1. Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр мэргэжлийн диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэхтэй байх;
2. Тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр тасралтгүй ажилласан байх,
3. Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх;
4. Жил тутам биелүүлсэн багц цагийн сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж буй мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр байх;
5. Ажилладаг байгууллага, хамт олны хөгжилд хувь нэмэр оруулах үйл ажиллагааг жил тутам зохион байгуулсан байх
6. Тухайн мэргэжил, үндсэн мэргэшлээр ажилласан сүүлийн 5 жилд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;

Мэргэжлийн тэргүүлэх зэрэг горилогчид (ЭМУЗБ) тавигдах тусгай шаардлага

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг, санаачлагатай гүйцэтгэж ирсэн, хамт олны хүндэтгэлийг хүлээсэн (хамт олны хурлын тэмдэглэл)
2. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 3-аас доошгүй илтгэл 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх)
3. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 5-аас доошгүй өгүүллийг 1-р зохиогчоор болон хамтран зохиогчоор хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод, гадаадад мэргэжлийн сургалтанд хамрагдсан байх (гэрчилгээ болон сургалтанд хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил бүрээр хавсаргах;

ЗӨВЛӨХ ЗЭРЭГ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ НИЙТЛЭГ БОЛОН ТУСГАЙ ШААРДЛАГА

Мэргэшлийн зэрэг горилогчид тавигдах нийтлэг шаардлага

1. Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр мэргэжлийн диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэхтэй байх;
2. Тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр тасралтгүй ажилласан байх;
3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх (мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардагдах мэргэжилд хамаарна);
4. Жил тутам биелүүлсэн багц цагийн сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж буй мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр байх;
5. Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх;
6. Тухайн мэргэжил, үндсэн мэргэшилээр ажилласан сүүлийн 5 жилд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;
7. Мэргэшлийн чиглэлээр 5-аас доошгүй удаа хамтран ажилладаг байгууллагуудад зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байх;
8. Ажилладаг байгууллага, хамт олны хөгжилд хувь нэмэр оруулах үйл ажиллагааг жил тутам зохион байгуулсан байх;
9. Тухайн мэргэжил/мэргэшлийн чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалтыг 2-оос цөөнгүй удаа зохион байгуулж, үр дүнг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байх;

Мэргэшлийн Зөвлөх зэрэг горилогчид (ЭМУЗБ) тавих тусгай шаардлага

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг, санаачлагатай гүйцэтгэж ирсэн, хамт олны хүндэтгэлийг хүлээсэн (хамт олны хурлын тэмдэглэл)
2. Сүүлийн 8 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 3-с доошгүй илтгэл, үүнээс гурав нь 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх)
3. Сүүлийн 8 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд 3-оос доошгүй өгүүлэл 1-р зохиогчоор хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод, гадаадад мэргэжлийн сургалтанд хамрагдсан, сүүлийн 8 жил тус бүр 2 багц цагийн сургалтанд хамрагдсан байх (гэрчилгээ болон сургалтанд хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил бүрээр хавсаргах)
5. Эрүүл мэндийн удирдлага чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн бол давуу тал болно.